

**УЛС ТӨР**

ТЭТГЭВЭРТ ГАРАХДАА АВДАГ  
ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭГ 36 ХҮРТЭЛХ  
САР БОЛГОХ НЬ

II нүүрт

**ОНИЦЛОХ ХУУДАС**

С.ЗОРИГИЙН ХЭРЭГ ЮУ БОЛОВ

V нүүрт

**УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА**



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын **60** мөр

Будаа “булаад”  
буян болох нь  
юу л бол

Ж.ОТГОНМЯГМАР

Хүмүүн сүүлчийн амьсгалаа дотогш хураасны дараа гурав хоногийн дотор сүнс биеэс салснаас эхлээд дараагийн төрлөө авах хооронд зуурдын төрөл буюу завсрын ертөнцөд төрөл авах шалтгаан бүрдтэл оршдог гэдэг. Шинэ төрөл авах нөхцөл бүрдтэл долоо долоо хоногийн хугацаатай хамгийн удлаа гэхэд 49 хоногийн дотор төрлөө олдог хэмээх бурхан шашны зан үйлд тусгагдсан байдаг. Энэ үед араас нь буян сайн үйлдсэн бол сайн төрөл авч, хэрэв буян сайн хийгээгүй бол амьд сэрүүн цагтаа хийсэн үйлийн үрээс хамаарч сайн муу төрлийн аль зохихыг авдаг ч хэмээдэг. Тийм учраас нас барагсдын хойноос буян хийхийг монголчууд урьтал болгодог. Хийх ч ёстой гэдэгтэй санал нийлж байна. Тэгэхдээ буян үйлдэж байгаа нь энэ гээд Монголын уул талаар нэг суварга босгож, хадаг уяад байгаа нь зүйд нийцэхгүй санагдана.

Үргэлжлэл нь II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## АРДАА “АЦАГ”-ТАЙ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

Х.НОРЖИН

УИХ-ын даргын захирамжаар ээлжит бус чуулган хуралдаж, өнгөрсөн баасан гарагт хаалгаа хийв. Ээлжит бус чуулган хуралдуулах тухай УИХ-ын дарга М.Энхболдын 2016 оны наймдугаар сарын 24-ний өдрийн “Улсын Их Хурлын ээлжит бус чуулган товлон зарлах тухай 09 тоот захирамж”-д “Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2016 оны наймдугаар сарын 25-ны өдрөөс есдүгээр сарын 15-ны өдрийг хүртэл зарлан хуралдуулна” гэж товлосон авч хугацаанаас нь зургаа хоногийн өмнө буюу 2016 оны есдүгээр сарын 9-ний өдөр албан ёсоор өндөрлүүлээ. Энэ нь орон нутгийн сонгууль ойртсонтой холбоотой

биз. Тэгээд ч хэлэлцэхээр төлөвлөсөн хуулийн төслүүдээс илүүтэй орон нутгийн сонгууль ойртсон энэ цаг үед иргэдийг бухимдуулж болохгүй гэсэн уур амьсгал дор явагдаж, үр дүн гэхээс илүү сонгогчдод тал засахыг чухалчилсан, ардаа “ацаг”-тай ээлжит бус чуулган болж өнгөрлөө гэж дүгнэж болохоор. Үүнийг УИХ-ын дарга М.Энхболдын ээлжит бус чуулганыг хааж хэлсэн үгнээс анзаарч болно. Тэрбээр “Чуулганаар нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, хямралын шинжтэй үеийг хохирол багатай даван туулах, цаашдын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эдийн засгийн бодлогын чухал шийдвэрүүдийг гаргалаа.

Үргэлжлэл нь III нүүрт

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**



## Г.ЗАНДАНШАТАР: ОЛОН ЦОРГОТОЙ ДАНХААР УЛСЫН МӨНГИЙГ УРСГАЖ БАЙСАН НЬ ИЙМ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮСГЭСЭН

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс



[www.facebook.com/PCmallOfficial](http://www.facebook.com/PCmallOfficial)  
[www.instagram.com/PCmall\\_Official](http://www.instagram.com/PCmall_Official)

Биднийг дагаарай

7575-3535

### ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 5000 SERIES



**БИД ТАНЫ АЖЛЫГ ХӨНГӨВЧИЛНӨ**

Inspiron 15 5000 загварын нөүтбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан Full HD дэлгэц, гайхалтай график үзүүлэлт, Intel® Core i5 процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

**Онцгой урамшуулал**

Dell брэндийн нөүтбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аваарай.



**Бэлгэнд**

- Үүргэвч
- 2 жилийн баталгаа
- McAfee вирусын програм

Хаяг: PC Mall төв: Их сургуулийн гудамж 31/1, Ш/Х: 346, Улаанбаатар - 14193, Сүхбаатар дүүрэг - 8

**ХААН банк**

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2225.00	2243.00	ФУНТ	2910.00	3006.00
ЕВРО	2472.00	2559.00	РУБЛЬ	33.30	36.30
ИЕН	21.54	22.14	ЮАНЬ	332.30	336.50

**Худалгаа хөгжлийн банк**

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2220.00	2243.00	ФУНТ	2904.00	3042.00
ЕВРО	2461.00	2581.00	РУБЛЬ	32.54	37.92
ИЕН	21.30	22.49	ЮАНЬ	332.00	336.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



*УИХ-ын дарга*  
**М. Энхболд**

*Гэрэл зурагч Г. АРТУУЖИН*

ҮЗЭЛ БОДОЛ

## АРДАА “АЦАГ”-ТАЙ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

**Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт**

Юуны өмнө бид Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн баталлаа. Үүгээр Улсын Их Хурлын сонгуульд оролцохдоо Монгол Ардын Намын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон бусад дунд, урт хугацааны хөгжлийн бодлого, зорилттой нягт уялдуулан ирэх дөрвөн жилийн бодлого зорилтоо

ухааны байгууллагынажилтнуудын цалингийн хэмжээг бууруулах тухай асуудлууд хэлэлцүүлгийн явцад хэл ам дагуулж, иргэд сонгогчдын дургүйцлийг ихээхэн төрүүлсэн тул АН-ын засгийн эрх барьж байх үедээ дэвшүүлж, хэрэгжүүлсэн хуулийн төслийн агуулгыг хэвээр нь байлгаж, зөвхөн нэрийг нь өөрчилснөөс хэтгэсэнгүй. Тухайлбал, Хамтын тэтгэврийн тухай хуулийн нэрийг өөрчилж “Насны хишиг” болгосон бол “Сайн оюутан” хөтөлбөр “Боловсролыг дэмжих сан”

Үндэсний тэтгэлэгт хөтөлбөрийг 2016 онд үргэлжлүүлэх болсонтой холбоотойгоор урсгал зардлыг 61.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж саналууд дэмжигдсэн юм. Мөн нийгмийн даатгалын сангийн орлогыг 530.4 сая төгрөгөөр, тус сангийн зарлагыг 28.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, Нийгмийн даатгалын сангаас санхүүжих хөрөнгө оруулалтын зардлыг 22.7 тэрбум төгрөгөөр бууруулснаар Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдлыг 51.0 тэрбум төгрөгөөр бууруулахаар шийдвэрлэснийг

байнгын хорооноос гаргасан горимын саналын дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлав. Мөн “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх явцад Төсвийн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хамтарсан хуралдаанаас 2017 оны төсвийн тухай хуулийн төслийг өргөн мэдүүлэхдээ өндөр насны тэтгэвэрт гарч буй төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг

ажилласан жилийг нь харгалзан 36 хүртэлх сарын хэмжээтэй байх талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулан 2016 оны төсвийн тухай хууль хэрэгжих эхлэх хугацаанаас тооцох чиглэлийг Засгийн газарт өгөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 92.7 хувь нь дэмжлээ. Үүгээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулган өндөрлөсөн. Дашрамд өгүүлэхэд, УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээг тогтоосон бөгөөд УИХ-аар хэлэлцэхээр төлөвлөсөн хууль, тогтоолын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх ажлыг Засгийн газар шуурхай зохион байгуулж, Байнгын хороод ээлжит чуулганы бэлтгэл ажлыг шуурхай хангахыг Засгийн газарт үүрэг болгов.



*Гэрэл зурагч Г. АРТУУЖИН*

тодорхойлоо. Ирэх дөрвөн жилийн бидний үйл ажиллагаа эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд тогтворжуулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнийн хамаарлыг бууруулах, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, өрийн дарамтыг зөөлрүүлэх, өсөлтийн суурийг хангах, улмаар эрчимжүүлэх, бүтээмж, үр ашгит тулгуурласан хөгжлийг бий болгоход чиглэгдэх болно. Эдийн засгийн хямралыг даван туулахад 2016 онд болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөв, санхүү, өрийн талаар баримтлах бодлогоо мөн тодорхойлоо” хэмээн онцолсон нь арай эртэдсэн үнэлэлт байлтай. Учир нь УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцүүлэхээр оруулж ирсэн 23 нэр төрөл бүхий хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан хуулийн төслүүдээс нийгмийн анхаарал татахуйц төсвийн тодотголд тусгагдсан татвартай холбоотой асуудлууд, түүнчлэн нийгмийн даатгал, хүний хөгжил сантай холбоотой хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэх үеэр давхар орж ирсэн “Хамтын тэтгэвэр”-ийн тухай хууль болон оюутны 70 мянга, хүүхдийн 20 мянган төгрөг, төрийн албан хаагчдыг өндөр настны тэтгэвэр гарахад нь нэг удаа буцалтгүй тусламж болгон нэг удаа олгодог 36 сарын цалинтай тэнцэхүйц тэтгэмж, шүүгч, эмч, багш, шинжлэх

нэртэйгээр хэрэгжихээр боллоо. За цаашлаад, хүүхдийн мөнгө, цалин тэтгэвэртэй холбоотой асуудлуудыг төсвийн тодотголын хүрээнд шийдэхээр байнгын хороодоор хэлэлцүүлээд ч тусыг эс олсон тул төслөө эргүүлэн татаж, хэлбэр хугацааг нь өөрчлөх төдий нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, иргэдийн бухимдлыг дарж, тэдэнд тал засах байдалд хүрсэн билээ. Ингээд ээлжит бус чуулганыг тоймлон хүргэе. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийв. Хуулийн төслүүдийг УИХ-ын бүх байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, УИХ дахь нам, эвслийн бүлгүүд хэлэлцэх явцад байнгын хороодоос томилогдсон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг үндэслэн улсын төсвийн орлогыг 3.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын зардлыг 65.0 тэрбум төгрөгөөр бууруулах, төрийн өндөр болон улс төрийн, төрийн захиргааны удирдах албан тушаалтны цалин, бүх шатны шүүхийн шүүгчийн, цалин, нийгмийн баталгааг хангахтай холбоотой зардлыг одоогийн түвшнээс бууруулахгүй байх, арьс ширний урамшуулал,

хуралдаанаар хэлэлцүүлсэн. Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.5-д зааснаар 2017 оноос эхлэн Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэнээр Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сан, Нийгмийн даатгалын сангуудын 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь батлахыг чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 94.4 хувь нь дэмжсэн бол Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гишүүдийн 90.7 хувийн, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 94.4 хувийн саналаар тус тус баталсан. Дараа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гишүүдийн 90.7 хувийн, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 94.4 хувийн саналаар тус тус баталсан.

- УИХ-ЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛСАН ХУУЛИЙН ТӨСЛҮҮД**
- 1/ “Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
  - 2/ “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
  - 3/ “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
  - 4/ “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
  - 5/ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
  - 6/ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд
  - 7/ Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд
  - 8/ Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
  - 9/ Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл
  - 10/ Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
  - 11/ Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
  - 12/ Батлан хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд
  - 13/ Зэвсэгт хүчний тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд
  - 14/ Цэргийн албаны тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд
  - 15/ Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд
  - 16/ Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл
  - 17/ Монголбанкны дэд ерөнхийлөгчийг чөлөөлөх, томилох тухай асуудал
  - 18/ “Зарим хууль, тогтоолын төсөл буцах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
  - 19/ “Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
  - 20/ Үндсэн хуулийн пэцийн 2015 оны 16 дугаар дүгнэлт
  - 21/ Үндсэн хуулийн пэцийн 2016 оны 04 дүгээр дүгнэлт
  - 22/ Үндсэн хуулийн пэцийн 2016 оны 07 дугаар дүгнэлт
  - 23/ Үндсэн хуулийн пэцийн 2016 оны 08 дугаар дүгнэлт гэсэн хуулийн төслүүд батлагдав.

## УЛС ТӨР

## УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Ж.ОТГОН

УИХ-ын гишүүн  
Г.Занданшатартай ярилцлаа.

**-2016 оны төсвийн хүрээний мэдэгдлийг сонслоо. Төсөв алдагдалтай хүндхэн байна. Ер нь улс орны эдийн засгийг сайжруулах ямар гарц байх шиг байна?**

-Төсвийн орлого бол тэгш татварын зарчимтай, нэг шатлалтай татвартай буюу илүү барууны чиглэлийн бодлоготой. Харин зарлага болохоор зүүний чиглэлийн бодлоготой. Дундах зөрүүг нь ашигт малтмалын үнийн өсөлтийн орлогоор нөхдөг. Ийм л төсөв байсан. Тиймээс одоо бодит байдал дээр гажуудал нь илүү тод харагдаж байна гэсэн үг. Гэхдээ одоо улсын төсвийн гол зардал бол хүүгийн зардал л байна. Тодруулбал, гадаадаас болон дотоодоос авсан зээлийн хүүгийн зардал нэг их наяд төгрөг байна. Ирэх жил төсвийн хүрээний мэдэгдэлд хүүгийн зарлага 1.5 их наяд болно. Энэ 1.5 их наядын хүү нь гадаадаас авсан 10.4 их наяд төгрөгийн Засгийн газрын зээлийн хүү, дотоодоос зээлсэн зээллэг буюу өрийн бичиг Засгийн газрын үнэт цаасууд, вексел, концесс нийлээд 1.3 их наяд төгрөгийн үнэт цаас, концессийн хэлцлүүдээс бүрдэж байгаа юм. Тэр дундаа Засгийн газрын тогтоолтой, тогтоолгүй 15-16 хувийн хүүтэй векселүүдийг гаргачихсан. Энэ бүх өрийн бичгийн болон Засгийн газрын зээллэгийн хүү нь 1.5 их наяд болж, гол ачаалал үүсгэж байна. Гэхдээ дамжуулан зээлдүүлэх гэрээ, Хөгжлийн банкаар олгосон зээл,

тавиад байгаа. Энэ нь хэн нэгний мууг үзэх гээд байгаа юм биш. Зүгээр л хүмүүст өгсөн мөнгөө буцааж авах хэрэгтэй. Ард түмний нуруунд ачаалал үүрүүлэх бус бодит байдал дээр үрэн таран хийснээ зөв зүйтэй ашиглах л асуудал юм. Тэр мөнгөөр үнэхээр байшин барьж босгосон бол түүнээс чинь өгөөж байх учиртай. Төсвийн өгөөжөөр төсвийн зээлийн ашиглалтын үр өгөөжийг тодруулах ёстой. Нэг тал нь 1.5 их наяд төгрөгийн хүүгийн зарлага гаргаад ирсэн. Тиймээс тэр хэмжээний өгөөжтэй байж гэмээн төсөв амьдрах ёстой шүү дээ. Гэтэл тэр өгөөж нь хаана байна гэдэг асуудал яригдаж байгаа. Энэ бүх дүр зургийг нэгтгээд, ерөнхийдөө төрийн болон нийгмийн үйлчилгээг илүү хүртэж байгаа хүн илүү татвар төлөх ёстой гэсэн чиг шугам гарч ирж байгаа юм. Тухайлбал, АНУ-д хүн амын орлогын албан татвар гэхэд 45 хувь хүртэл байдаг. Харин Японд өв залгамжлалын татвар 80 хувь байдаг. Тэгвэл Шведэд бүр 65 хувь хүртэл татвар төлдөг. Өөрөөр хэлбэл, нийгмийн баялгаас их авч байгаа хүн нь илүү төлөх ёстой гэсэн зарчим үйлчилдэг. Тухайн хүн Хавайд ч юм уу, гадагшаа явж зугаалах зардлаа хэмнэж, 40-45 хувийн татвараа төлөх ёстой гэдэг. Энэ мэт татварын уян хатан системүүд байдаг. Нөгөө талдаа татварыг бууруулдаг. Тухайлбал, бага орлоготой иргэн буюу сая хүртэл төгрөгийн орлоготой иргэн таван хувийн татвар төлж болно. Өнөөдөр бүх хүн 10 хувийг төлж байгаа. Тэгвэл 1-2 сая төгрөгийн орлоготой бол 10 хувь төлөх, хоёр сая төгрөгөөс

...1.5 их наядын хүү төлж байгаа, дөрвөн их наядын алдагдалтай компанийг хэн нэгэн авлаа гэж бодьё. Тэр хүн тухайн компанийг яаж сайжруулах вэ. Дотоодын нөөц бололцоо хязгаарлагдмал, дотоодын бүх нөөц бололцоогоо шавхахын зэрэгцээ гаднаас зээл авахаас өөр аргагүй байдалд хүрнэ. Зүгээр аялаар жишээд үзье. 1.5 их наядын хүү төлөх, цаана нь 10 их наядын өртэй, тэгсэн хэрнээ бизнес нь дөрвөн их наядын алдагдалтай. Тэгвэл энэ айл амьдралаа өөд нь татахын тулд дахиад зээл авна. Дотооддоо бүх шүүсээ шахна...



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

## Г.ЗАНДАНШАТАР:

## ОЛОН ЦОРГОТОЙ ДАНХААР УЛСЫН МӨНГИЙГ УРСГАЖ БАЙСАН НЬ ИЙМ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮСГЭСЭН

Монголбанкны олгосон дөрвөн их наяд төгрөгийн зээлүүд бол арилжааны банкуудтайгаа өрсөлдөөд зах зээлийн банкны системийг гажуудуулаад олгочихсон зээлүүд байгаа юм. Эдгээр зээлийн зориулалт, үр ашиг нь юу байсан бэ гээд энэ бүх тоо баримтуудтай нь харьцуулаад харж байхад үндсэндээ манайх бол өрийн болоод хариуцлагын хямралыг л бий болгочихож. Хариуцлага гэдэг нь төсвийн сахилга багын хямрал. Харин төсвийн сахилга бат гэдэг бол төсөвт суусан зүйлийг чанд үр ашигтай зарцуулах асуудал. Гэтэл тэгж чадаагүй. Төсөвтөө огт суулгагүй зардлыг гаргаад ирсэн. Засгийн газар нь тогтоолоор зардал гаргаад ирсэн хэрэг. Тэгээд байр, байшин худалдаж аваад байсан. Тиймээс бидний тавьж байгаа шаардлага бол төсвийг эрүүлжүүлэхийн тулд хариуцлагын механизмыг л ажиглуулах юм.

**-Тэгвэл хэний болгочихсон юм гэдгийг тодруулах хэрэгтэй болно шүү дээ?**

-Чуулганы анхны өдрөөс л хэн ийм болгов гэдэг асуулыг

дээш бол 15 хувь төлж болно. Харин гурван сая төгрөгөөс дээш орлоготой бол 20, 3.5 сая төгрөгөөс дээш орлоготой бол 25 хувийн татвар төлж байх жишээтэй. Ийм систем дэлхийн ихэнх улсад үйлчилдэг. Их орлоготой байх тусмаа төрийн болон нийгмийн үйлчилгээг илүү хүртэж байгаа гэдэг үүднээс ачаалал үүрдэг систем байдаг. Гэхдээ ингэснээрээ ажилгүй иргэдээ ажилтай болгох, нийгмээ чирч явах гээд төсвийн ачаалал жигдэрч болно. Гэтэл одоо бол эдийн засаг маш хүндэрчихсэн, төсвийн алдагдал 20 хувьтай багтаагдана гэдэг нь мөнгөний ханш эрс унана гэсэн үг. Эдийн засгийн том зургаар харвал мөнгөний, сангийн, татварын бодлогууд бүгд уялдаж өгсөн. Бодлогын хүүг өсгөнө гэдэг бол мөнгийг үнэтэй болгож байгаагаас гадна ховор болгож байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, банкны мөнгийг татаж байгаа юм. Татвар ч ачаалал үзүүлнэ. Тиймээс дахин хуваарилалтын үүрэг бол төсвийн, сангийн, татварын бодлого байдаг. Тэгэхээр энэ бүхнийг олон хэлбэрээр зөв

зүйтэй болгож, ухаалаг бодлого явуулж чадвал Монголын эдийн засагт гэрэл гэгээ авч ирэх хөрөнгө оруулалт, концессийн үр өгөөжийг сайжруулах боломж бий. Харин үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд хариуцлагатай байх хэрэгтэй. Хулгайг зогсоож, зарчимтай байх шаардлагатай. Төсвийн сахилга багыг сайжруулах хэрэгтэй байна. Ингэж чадвал жижиг эдийн засагт том өөрчлөлтийг богино хугацаанд хийх бололцоотой.

**-Өрийн таацыг нэмэх асуудал нэлээд шүүмжлэл дагуулаад байна. Өрийн таацыг нэмэхээс өөр гарц байхгүй байсан уу?**

-Өрийн таац бол өөрөө үндсэндээ буруу тооцогдоод явж байсан байна. Уг нь өрийн таац 55 хувь байх ёстой. Гэтэл бодит байдал дээр гаргасан векселүүдээс болоод Засгийн газрын гадаад, дотоод өрүүдийг нийлүүлээд үзэхээр нэлээд өндөр тоо гарна. Тиймээс оны эцсийн үлдэгдлийн байдлаараа 81 хувь болчихоод байгаа юм. Тиймээс дахин зээл авахын тулд өрийн таацыг нэмэгдүүлээд

байгаа юм биш. Харин бодит байдал нь буюу Засгийн газрын төлөхөөр хүлээгдэж байгаа өрийн гүйцэтгэл өндөр байгаа. Энд Серби улсын жишээг дурьдаж болох юм. "Стэнд бай" хөтөлбөрийг аваад, татвараа нэмээд, төсвийн зардлаа бууруулсан. Гэтэл 16 хувийн хүүтэй байсан бонд нь өнөөдөр зургаан хувь болчихоод байна. Ердөө 45 жил хатуу чанга, хариуцлагатай бодлогыг шинэ Засгийн газар нь хэрэгжүүлээд зургаан хувийн хүүтэй болоод байгаа юм. Гэтэл өнөөдөр манайд дотоод зээлдээ 15-16 хувийн хүү төлж байна. Гадаадын зээлдээ 10.4 орчим хүү төлж, бондын хүү нь 8.4, 10.4 хувьд хэлбэлзэж байна. Тэгэхээр ингэж бууруулах нь төсвийн тогтвортой байдлын ирээдүйд хангах хамгийн гол чиглэл юм. Серби улс ийнхүү бууруулж чадсан байхад Монгол Улсын хүү хэлбэлзээд өсөөд байна. Одоо 1.5 их наяд төгрөгийн хүүгийн төсвийн зарлага хамгийн үр ашиггүй зарлага болоод байгаа. Гэтэл энэ мөнгөөр хэчнээн сургууль, эмнэлэг барьж болох вэ. Гэтэл

үүнийг л зээлийн хүүнд төлөөд байна. Хүнээр бол зээл авчихлаа. Нэг талдаа 1.5 их наядын хүү төлөөд байна. Харин талд нь авсан зээлээс нь орж ирдэг юм байхгүй. Юунд зээлээ зарцуулсан нь мэдэгдэхгүй, хашаагаа тохижуулчихсан ч юм уу. Мөнгө олдог зүйлд зарцуулаагүй тухайн айл хэцүүднэ биз дээ. Бодит байдал яг л ийм байна.

**-Сөрөг хүчний зүгээс эрх баригчид өрийн таацыг нэмж, дахин бонд гаргаж, ганцхан улсаас хараат болох нь гэж яриад байгаа?**

-1.5 их наядын хүү төлж байгаа, дөрвөн их наядын алдагдалтай компанийг хэн нэгэн авлаа гэж бодьё. Тэр хүн тухайн компанийг яаж сайжруулах вэ. Дотоодын нөөц бололцоо хязгаарлагдмал, дотоодын бүх нөөц бололцоогоо шавхахын зэрэгцээ гаднаас зээл авахаас өөр аргагүй байдалд хүрнэ. Зүгээр аялаар жишээд үзье. 1.5 их наядын хүү төлөх, цаана нь 10 их наядын өртэй, тэгсэн хэрнээ бизнес нь дөрвөн их наядын алдагдалтай. Тэгвэл энэ айл амьдралаа өөд нь татахын тулд дахиад зээл авна. Дотооддоо бүх шүүсээ шахна. Одоо Монгол Улс хөтөлбөрт хамрагдана гэдэг бол зээл авна гэсэн үг. Нэг бол бусад улсаас зээл авна. Энэ бол зайлшгүй хийгдэх ёстой л ажлын нэг. Гэхдээ эцсийн дүндээ зээл, хуулиасаа илүү засаглалын

хариуцлага, төсвийн сахилга бат, хууль дээдлэх зарчмыг бий болгож байж л улс хөгжинө.

**-Монгол Улс өнгөрсөн хугацаанд хэд хэдэн төсөвтэй явж ирсэн гээд байгаа. Энэ ер нь юугай холбоотой юм бэ?**

-Энэ удаагийн төсвийн алдагдал хэдийгээр өндөр гарч байгаа ч гэлээ бүх төсвийг нэгтгэсэн. Тиймээс ч асуудал гарч байгаагаас гадна өрийн таац зөв болж ирж байгаа юм. Тухайлбал, Хөгжлийн банкны нэр дээр авсан зээл бүртгэгдэхгүй, МИАТ-ийн нэр дээр байгаа зээл бүртгэлгүй яваад байсан. Гэтэл улсын баталгаа гаргаад авсан зээл бүгд олон улсын стандартаар зарчмаар бол өрийн таацад орж байх ёстой. Бүгдийг нь төсөвтөө оруулаагүй байсан учир өрийн таац бага юм шиг харагдаад байсан хэрэг. Тэгвэл өнөөдөр өрийн таац 81 хувь болоод байгаа нь энэ олон тараачихсан байсан зүйлүүдийг нэгтгэж, бодит төсөв гаргаж ирж байгаа юм. Хөгжлийн банк төсөв мөнгө нь тодорхойгүй зээл, хөрөнгө оруулалтын төсөл, Хүний хөгжлийн сан гээд төсөл хэрэгжүүлээд байдаг. Тэнд Монголбанк нь арилжааны банкуудтай өрсөлдөөд зээл олгоод байдаг. Энд улсын төсөв гээд баахан юм хийгдээд байдаг. Энэ мэтчилэн улсын мөнгө олон салаагаар урсч байсан гээд, зайлшгүй олгох тэтгэвэр, тэтгэмжийг зогсоож болохгүй. Тэгвэл өөр ямар боломж байж болох вэ гэхээр хөрөнгө оруулалтаа танах, том төслүүдээ өргөжүүлэх, зээл авах шаардлага тулгарна. Харин авсан зээлээ бодитой зүйлд л зарцуулах хэрэгтэй. Тиймээс Олон улсын валютын сангаас хэрэгжүүлдэг "Стэнд-бай" хөтөлбөрт хамрагдана гэдэг бол зээл авна гэсэн үг. Нэг бол бусад улсаас зээл авна. Энэ бол зайлшгүй хийгдэх ёстой л ажлын нэг. Гэхдээ эцсийн дүндээ зээл, хуулиасаа илүү засаглалын

# МОНГОЛЫН МЭДЭЭ

18 000 ХАМТЭЙ

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **64** дугаар

Захиалгын үнэ **18000**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# С.ЗОРИГИЙН ХЭРЭГ ЮУ БОЛОВ

С.Зоригийн хэргийг илрүүлнэ гэх амлалтыг үе үеийн улстөрчид сүүлийн 10 гаруй жилийн турш өгсөөр л ирсэн. Гэвч харамсалтай нь илрээгүй л байна. 2016 оны сонгуулийн өмнө ч гэсэн энэ хэргийг илрүүлэх асуудал босч ирсэн. С.Зориг агсны эхнэр Д.Булганыг хүртэл барьж хориод бараг л жил болох гэж байна. Энэ урт хугацаанд хэрэг илрүүлэх ажил нааштай явж байгаа бил үү. Гэх мэтээр олон асуулт байгаа. Тэгвэл "Монголын мэдээ" сонин энэ удаагийн "Онцлох хуудас"-аараа С.Зоригийн хэргийг шалгах ажлын эргэн тойрон дахь асуудлыг онцоллоо.

### С.ЗОРИГ АГСНЫГ ХӨНӨӨСӨН СЭЖИГТНҮҮД ХЭН БЭ

**2016.09.07:** Хамгийн сүүлд С.Зориг агсны хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан хүмүүс хэн болохыг цахим сайтууд мэдээлж эхэллээ. Өнөөх хуулийн байгууллагуынхны нуугаад байсан Д.Булгантай хамт баривчилсан хүмүүс шүү дээ. Тэд Орхон аймгийн харьяат Б.Содномдаржаа, Т.Чимгээ, Ц.Амгаланбаатар нар. Энэ хүмүүс хоорондоо хамаатан аж. Энэ талаар цахим сайтууд "Ц.Содномдаржаа нь 42 настай, Ц.Амгаланбаатар нь 35 настай, Т.Чимгээ нь мөн 40 гаруй насны эмэгтэй аж. Өөрөөр хэлбэл, сэжигтэн этгээдүүд С.Зориг агсныг алагдах үед 16-25 настай байжээ. Тэднийг ийнхүү нэрт улстөрчийн хэрэгт холбогдсон асуудлаар ар гэрийнхэн нь Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Хүний эрхийн үндэсний комисст гомдол гаргасан байна" хэмээн мэдээлж байна.

### Д.БУЛГАНЫГ БАРИВЧИЛЖЭЭ

**2015.11.16:** Өнгөрсөн жилийн сүүлчээр гэнэт л С.Зориг агсны гэргий Д.Булганыг баривчилж, нийгэм даяар шуугиан тарьсан. Энэ талаар цахим сайтууд "УИХ-ын гишүүн асан, Дэд бүтцийн сайд асан С.Зоригийн гэргий Д.Булганыг өнгөрсөн баасан гарагийн шөнө гэрээс нь баривчлан цагдан хорих 461 дүгээр ангид саатуулжээ. Яг ямар хэрэгт Д.Булганыг буруутган саатуулан шалгаж буй талаараа хуулийн байгууллагуынхан дэлгэрэнгүй тайлбар өгөхөөс татгалзлаа. Эх сурвалжийн мэдээлснээр одоохондоо Д.Булганыг цагдаагийн байгууллагын эрхийн хүрээнд 72 цагийн хугацаатай саатуулсан байна" хэмээн мэдээлсэн юм.

### ЦЕГ: Д.БУЛГАНЫГ БАРИВЧИЛСАН НЬ ҮНЭН

**2015.11.17:** С.Зориг агсны эхнэр Д.Булганыг баривчилсан нь үнэн үү гэх асуулт тэр дороо л олны сонирхлыг татсан. Тэгвэл ЦЕГ-аас энэ мэдээлэл гарсны дараахан мэдээлэл хийсэн юм. Энэ талаар цахим сайтууд "ЦЕГ-аас сэтгүүлчдэд өгсөн бөгөөд "Д.Булганыг саатуулсан нь үнэн. Харин хэрэг мөрдөн байцаалтын шатандаа явж буй учир ямар нэгэн мэдээлэл өгөхгүй боломжгүй" гэсэн юм. Одоогоор Д.Булганыг ямар хэргээр саатуулсан нь тодорхой бус байна. Гэхдээ албаны эх сурвалжийн мэдээлж буйгаар хэргийн мөрдөн байцаалтыг эхлүүлсэн гэнэ. Уг нь түүнийг өнгөрсөн амралтын өдөр саатуулсан юм. Мөн Д.Булгантай хамт хоёр иргэнийг саатуулсан гэх мэдээлэл ч байна. Ямартай ч, С.Зориг агсны эхнэр Д.Булганыг өнгөрсөн баасан гарагийн шөнө гэрээс нь баривчилж, ШШГЕГ-ын харьяа цагдан хорих 461 дүгээр ангид саатуулсан юм. Харин түүнийг ямар шалтгаанаар саатуулсан нь одоогоор тодорхойгүй байна" хэмээн мэдээлж байлаа.

### Э.АМАРБАТ: С.ЗОРИГИЙН ХЭРЭГТ Б.БУЛГАНААС ГАДНА НЭГ БУС ХҮНИЙГ СЭЖИГТНЭЭР ТАТСАН

**2016.08.17:** Цагдаагийн газраас С.Зориг агсны эхнэр Д.Булганыг баривчлан хорьсон нь нэг хэсэгтээ л шуугиан тарьсан. Гэвч тэгсхийгээд мартагдаж, сураг нь алдарсан. Хааяа нэг түүний тухай мэр сэр мэдээлэл гарч байсныг эс тооцвол. Харин өнгөрсөн наймдугаар сард Улсын прокурорын газраас мэдээлэл хийх үеэр зарим нэг зүйл тодорхой болсон юм. Улсын прокурорын туслах, хэлтсийн дарга Э.Амарбат "С.Зориг агсныг хөнөөсөн хэрэгт Б.Булганаас гадна нэг бус хүнийг сэжигтнээр татаж, саатуулан байцааж байгаа. Энэ хэрэг нь нууцын зэрэглэлтэй учраас үүнээс илүү мэдээлэл өгөхгүй" гэсэн юм.



### С.ЗОРИГИЙГ ХӨНӨӨСӨН ЭТГЭЭДҮҮД ОЛДОВ УУ

**2016.04.25:** Төрийн нэрт зүтгэлтэн, Ардчиллын "Алтан хараацай" С.Зоригийг хөнөөсөн байж магадгүй гэх сэжигтнүүдийг олон талаар баттай бус мэдээллүүд маш их цацагдсан. Тухайлбал, зарим сайтууд "С.Зориг агсныг хөнөөсөн гэмт этгээдүүдийг илрүүлсэн гэх мэдээлэл байна. Эх сурвалжийн мэдээлснээр уг хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан этгээдүүдийг бүхий улстөрч агсны малчид болох Г, С гэгч болохыг хэрэг үйлдсэн хутгаар нь нотолсон гэнэ. Мөн тэдэнтэй хамт дээрх улстөрчийн малыг хариулдаг нэгэн эмэгтэйн үс хэргийн газраас олдсон тул баривчлан хорьсон гэх. Улмаар үсийг нь Япон улсад шинжлүүлсний дүнд ДНК нь бүрэн нийлж байгааг баталсан гэх мэдээлэл байна. Харин сэжигтэн этгээдүүдийн эзэн нь одоогоор амьд бус гэдгийг эх сурвалж мэдээлжээ" гэх мэдээлэл гарч байлаа.

### Д.БУЛГАН ХУДАЛ МЭДҮҮЛЭГ ӨГЧ ХЭРЭГ ИЛРЭХ ЯВЦЫГ УДААШРУУЛСАН ГЭНЭ

**2015.11.17:** Д.Булганыг яагаад хорьж, саатуулав гэдэг асуулт нэг хэсэгтээ л явсан. Цагдаагийн газраас түүнийг яагаад хорьсон талаар дорвитой мэдээлэл өгөөгүй. Харин зарим цахим хуудсууд худал мэдүүлэг өгсөн нь нотлогдсон учраас хорьсон хэмээн бичиж байв. Тухайлбал, "С.Зориг агсны амийг хөнөөсөн этгээдүүдийн нэг нь эрэгтэй, нөгөө эмэгтэй хүн байсан гэж энэ хэргийн цорын ганц гэрч Д.Булган өнөөг хүртэл мэдүүлж ирсэн байдаг. Гэтэл тус хэргийг шалгаж буй ажлын хэсгийнхэн 2-3 жилийн өмнө С.Зориг агсны амь насыг хоёр эрэгтэй хүн хөнөөсөн гэдгийг шалгалтын явцад олж тогтоосон байна. Ингээд тус хэргийн гэрч Д.Булган "Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн С.Зоригийн амь насыг хөнөөсөн" гэж худал мэдүүлэг өгч, аман зургийг худал гаргуулж, хэрэг илрэх явцыг удаашруулсан гэж цагдан хорьсон бололтой. Зарим эх сурвалжийн мэдээлснээр С.Зориг агсны амь насыг хөнөөсөн хэрэгт сэжиглэж 40 гаруй насны хоёр эрэгтэй хүнийг Орхон аймгийн Эрдэнэт хотоос сар гаруйн өмнө барьж, цагдан хорих 461 дүгээр ангид саатуулсан байна" хэмээн мэдээлж байв.

## Сэтгүүлчийн өнцөг

# С.ЗОРИГИЙН ХЭРЭГ ИЛРЭХ ҮҮ

Н.ПУНЦАГБОЛД

Хэрэг хуучирдаггүй л гэдэг. Ингэж бодвол тэртээ 20-нод жилийн өмнө С.Зориг агсныг хөнөөсөн гэмт этгээдүүдийг барьж, хэргийг илрүүлж болох юм. 20 орчим жилийн хугацаанд зүгээр л сонгуулийн шоу маягтай байсан С.Зориг агсны хэрэг одоо л нэг юм жинхэнээсээ илэрч байна уу гэмээр үйл явдлууд энэ жил өрнөлөө. Өнгөрсөн оны төгсгөлд С.Зориг агсны эхнэр Д.Булганыг баривчилсан. Улмаар хэд хэдэн сэжигтнийг баривчилсан нь энэ хэргийг илрүүлж болох юм гэдэг горьдлогыг илүү бодит болгосон. Гэвч яг

бодит байдал дээрээ илрэхээр хэмжээнд хүрсэн үү гэдэг нь бас л эргэлзээтэй байна. Учир нь өнөөх сэжигтнээр татаад байгаа хүмүүс нь 20-нод жилийн өмнө 16-20 гаруй насны өсвөр үеийнхэн байсан байгаа юм. Улстөрч, нэр хүндтэй, дээрээс нь бие хамгаалах урлагаар хичээллэдэг байсан хүнийг өсвөр насны охин, хүү хоёр хөнөөчихдөг гэдэг юу л бол. Тэгээд ядаж байхад Ц.Амгаланбаатарг гэгч алуурчны аман мэдүүлгээр л энэ бүхэн өрнөөд байгаа юм. Ц.Амгаланбаатар гэгч нь таксины жолоочийг хөнөөгөөд, бүрмөсөн хэрэгцгий алуурчин. Хүний санаанд багтамгүй жигшүүрт хэрэг хийсэн энэ

нөхөрт шүүхээс цаазын ял оноосон юм билээ. Гэвч Ерөнхийлөгчийн өршөөлөөр 25 жилийн ял эдлэхээр болсон байгаа юм. Тэрбээр энэхүү аймшигт хэргийг 2007 онд үйлдсэн. Харин энэ хүн ял эдэлж байхдаа гэнэт л "Би С.Зориг агсныг хөнөөсөн. Надтай хамт Т.Чимгээ, Б.Содномдаржаа нар явсан. Б.Содномдаржаа үүдэнд хүн харж байсан. Т.Чимгээ С.Зориг агсныг хөнөөсөн хутгыг муу усны нүх рүү хийсэн" хэмээн мэдүүлж. Үүнээс үүдээд л тэр хүмүүсийг баривчилчихаад байгаа аж. Б.Содномдаржаа бол Ц.Амгаланбаатар гэгч жигшүүрт алуурчны өргөж авсан ээжийнх нь дүү юм билээ.

Харин Т.Чимгээ нь түүний бэр эгч. Хамгийн сонирхолтой нь С.Зориг амь насаа алдсан хэргийг өөртөө хүлээгээд байгаа Ц.Амгаланбаатар энэ хэрэг гарах үед дөнгөж 16 настай байсан гэдгийг дээр үед Т.Чимгээ төрөөд удаагүй, Дорнод аймагт амьдарч байсан аж. Хэргийг үйлдсэн гээд байгаа Ц.Амгаланбаатар хот ч орж үзээгүй 16 настай хүү байсныг, Б.Содномдаржаа тэр үед хөдөө мал маллаж байсан гэдгийг гэрчүүд мэдүүлж байгаа ч мөрдөн байцаагчид тэднийг мэдүүлгийг тоож ч авч хэлэлцэхгүй байгаа гэдгийг хэвлэлийнхэн мэдээлсээр л байна.

Хууль хяналтынхан цаазын ял сонссон Ц.Амгаланбаатарт хэрэг хүлээлгэж, Б.Булганыг худал мэдүүлэг өгсөн хэргээр яллаж, Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарыг хэлмэгдүүлэх гэж байна гэсэн гомдлыг ар гэрийнхэн нь гаргаж байгаа юм. Сэжигтнүүдийн өмгөөлөгчид УИХ-ын дарга, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хүний эрхийн комисст хүртэл гомдол гаргажээ. Одоохондоо нэг иймэрхүү үйл явдал өрнөөд байна. Ингээд бодохоор С.Зориг агсны хэрэг илэрч байгаа гэдэг нь эргэлзээтэй болчихсон юм биш үү. Хүний амийг хэрцгээгээр хөнөөсөн нэг муу алуурчны үг гэмгүй ах, этчийгээ чирж "тоглож" байгаа

тоглоом болчихоогүй байгаа даа. 25 жилтэй ялтан бол юу ч гэж ярьж болно. Дээрээс нь хэнийг ч энэ "тоглоом"-доо хутгасан түүний дур. Ийм л дүр зураг энэ бүхнээс харагдаад байна. Хэвлэлүүд ч ингэж л бичээд байгаа. 2016 оны сонгуулийн өмнө эхэлсэн энэ хэрэг явдал сонгуулийн дараа ч үргэлжилсээрл байгаа юм. Одоо Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гээд төрийн томчууд эдгээр хүмүүсийн хувь заяаг хааш нь эргүүлэх нь сонин байна. Тэр лундаа Д.Булганы хувь заяа. Угтаа бол С.Зориг агсны хэрэг илэрвэл сайн л байх. Гэхдээ илрүүлж байгаа нэртэй гэмгүй хүмүүсийг хэлмэгдүүлэх вий дээ.

# ДЭЛХИЙ

Б.ДАВААХҮҮ

Өчигдөр есдүгээр сарын 11-ний өдөр тохиолоо. 2001 оноос хойш энэ өдрийг дэлхий нийт терроризмын аймшигт хор уршгийг санан дурсан өнгөрүүлдэг болсон билээ. 2001 оны яг энэ өдөр АНУ-ын улс төр, эдийн засгийн төвүүдийг устгахаар төлөвлөсөн алан хядагч бүлэглэлийн 19 этгээд иргэний агаарын тээврийн дорвонгоц барьцаалж, аймшигт халдлага үйлдэж байв. Онгоцны бүхээгт нэвтэрсэн алан хядагчид жолоодлогыг гартаа авч, эхний онгоц өглөөний 08.00 цагийн үед Нью-Йоркийн ихэр хоёр цамхаг буюу Дэлхийн худалдааны төвийн хойд



онд Америкийн 5300 цэргийн алба хаагч амиа алдаж, 50 гаруй мянга нь гэмтэж бэртсэнээс гадна нэг их наяд 600 тэрбум ам.долларыг зарцуулжээ. Тиймээс эдүгээ хүний амь болон хөрөнгө мөнгөний хувьд хохирол багатай байхаар терроризмын эсрэг тэмцэж буй.

Түүнээс хойш юу өөрчлөгдөв

Одоогоос 15 жилийн өмнө үнсэн товорго болсон Дэлхийн худалдааны төвийн суурин дээр эдүгээ тэрхүү аймшигт өдрийн дурсгалын хөшөө, музей баригдсанаас гадна

## ДЭЛХИЙГ ЦОЧИРДУУЛСАН ЕСДҮГЭЭР САРЫН 11

...Одоогоос 15 жилийн өмнө үнсэн товорго болсон Дэлхийн худалдааны төвийн суурин дээр эдүгээ тэрхүү аймшигт өдрийн дурсгалын хөшөө, музей баригдсанаас гадна 1776 фут өндөр Дэлхийн худалдааны төв баригдсан билээ. Харин иргэний агаарын тээврийн 77 дугаар нислэгийн онгоцоор нураасан Пентагоны ордны дотор талд халдлагаар амь үрэгдэгсдийн дурсгалын өрөө мөн бий...

уаанд нь хордсон хүмүүс асар өндөр барилгын дээрээс үсрэн амиа алдаж байсан аймшигт дүр зургийг Нью Йоркийн иргэд дэргэдээс нь харж байжээ. Ихэр цамхагийг үнсэн товорго болгосон дайралтад худалдааны төвийн барилга дотор байсан дэлхийн 70 гаруй улсын нийт 2000 гаруй иргэн амиа алдсан байдаг. Харин алан хядагчдад барьцаалагдсан дараагийн хоёр онгоцны нэг нь Арлингтон дахь АНУ-ын батлан хамгаалах яамны төв болох Пентагоны барилгыг мөргөн сүйрсэн юм. Пентагоны барилгад ихээхэн эвдрэл учирсан бөгөөд барилгыг сэргээн засварлахад нэг жил шаардагдаж байсан аж.

Харин дөрөв дэх онгоцны хувьд зарим зорчигч болон нисэх багийнхан барьцаалсан алан хядагчидтай тэмцэлдсэний эцэст алан хядагчдын зорьсон цэгт хүрэлгүй Пенсильван муж дах хөдөө хээр газарт унасан байна. Харамсалтай нь онгоцны зорчигчид, нисэх багийнхнаас нэг ч хүн амьд гараагүй юм. Тэднийг оролцуулаад террористуудын гэмт үйлдлээс болж нийтдээ 2996 хүн нас барж, 6000 гаруй хүн гэмтэж шархаджээ.

Халдлагын ард хэн байсан бэ

Египет, Леваны харьяат байжээ. Тэдний зарим нь Европт амьдардаг байв. Өмнө нь америкчуудад есдүгээр сарын 1-нийх шиг аймшигт өдөр ирнэ гэдгийг сануулах хэд хэдэн халдлага гарч байсныг энд дурьдах хэрэгтэй. 1993 онд Дэлхийн худалдааны төвд дэлбэрэлт болж байсан бол 1998 онд Кэни, Танзани дахь АНУ-ын Элчин сайдын яамыг мөн бөмбөгдөж байлаа.

Түүнчлэн, 2000 онд Иемэнд хөвж явсан USS Cole хөлөг онгоцыг Аль Кайдагийн дайчид сөнөөж байсан юм. Дэлхийн худалдааны төв ихэвчлэн оффис, худалдааны төв ихэвчлэн оффис, худалдааны зориулалтаар ашиглагдах долоон барилгын цогцолбор байжээ. 1970-аад оны эхэн үед барьсан ихэр хоёр цамхаг 1300 фийт өндөр байсан бөгөөд тухайн үедээ дэлхийн хамгийн өндөр барилгаар нэрлэгдэж байв. 1993 онд террористууд Дэлхийн худалдааны төвийн доор байрлах граахт бөмбөг дэлбэлж байжээ. Энэ үед зургаан хүн нас барж, 1000 гаруй хүн гэмтэж бэртсэн байна. Гэхдээ цамхаг дахин сүндэрлэн боссон. Дэлбэрэлтийн дараа Холбооны мөрдөх товчоо хэрэгт холбогдуулан хэсэг лалын шашинт террористуудыг баривчилж байсан юм.

Афганистан ба Иракийн дайн

Гурван мянга орчим хүн амиа алдаж, 70 гаруй мянган хүн хорт утаа, тоосжилтын улмаас үүдсэн өвчин тусч хөдөлмөрийн чадвараа алдсан аймшигт үйл явдал АНУ төдийгүй дэлхий нийтийг цочирдуулж, сэрээж чадсан юм. Халдлагаас ердөө сар орчим хугацааны дараа

Жорж Буш Афганистан дахь талибаны дэглэмийг арилгах, Осам Бин Ладены террорист ажиллагааны эсрэг цэргээ хөдөлгөж, Америкийн цэргүүд Афганистанд орж иржээ. Улмаар хоёр сарын дотор Талибаны дэглэмийг устгасан байдаг. Түүнчлэн Иракийн дайныг АНУ эхлүүлсэн нь мөн л эл хэргээс үүдэлтэй. Бушийн засаг захиргаа Аль Кайда бүлэглэл, Иракийн эрх баригчид хоорондоо холбоотой гэж үзэж байсан гэдэг. Түүнчлэн, Иракт хүн амыг олноор нь хөнөөх биологийн болоод химийн зэвсэг байгаа хэмээн хардаж, энхийг сахиулах нэрийн дор АНУ Ирак руу цэргээ оруулж байв.

Гэхдээ тийм зэвсэг байсан эсэх нь эргэлзээ төрүүлдэг аж. Хожим шинжээчид 1991 онд Иракийн тал уг зэвсгээ устгасан гэдгийг нотолсон гэх.

Ямартай ч, террористуудтай дайн зарласан Жорж Буш Афганистан, Ирак руу цэргээ хөдөлгөхдөө Аль Кайдагийн толгойлогч Бин Ладенаас хариугаа авах санааг далдхан тээж байсан гэж үзэх үндэслэл бий. Гэхдээ есдүгээр сарын 11-ний аймшигт халдлагыг удирдсан Аль Кайдагийн толгойлогч Бин Ладеныг үнэлж байсан удаа ч бий. Харин 2011 оны тавдугаар сарын 2-нд Пакистаны Абботтабадад ажиллагаанд оролцож байсан Америкийн тэнгисийн цэргийн бие бүрэлдэхүүн Бин Ладеныг хэсэг хамгаалагчийнх нь хамтаар хөнөөсөн байдаг билээ. АНУ-ын цэргийнхний албан ёсны мэдээллээр Ирак, Афганистанд цэргийн ажиллагаа явуулсан 2001-2014

1776 фут өндөр Дэлхийн худалдааны төв баригдсан билээ. Харин иргэний агаарын тээврийн 77 дугаар нислэгийн онгоцоор нураасан Пентагоны ордны дотор талд халдлагаар амь үрэгдэгсдийн дурсгалын өрөө мөн бий. Харин дөрөв дэх онгоц унасан хөдөө хээр талд онгоцонд зорчиж яваад харамсалтайгаар амиа алдсан иргэдийн дурсгалын талбай мөн байдаг ажээ. Эдүгээ терроризмд ганц АНУ анхаарлаа хандуулах бус, дэлхий нийт үүний эсрэг нэгдэж байна. Нөгөө талаар, Аль Кайда бүлэглэл одоо хүртэл оршин тогтносон хэвээр. Саяхан гэхэд тус бүлэглэлийн одоогийн удирдагч Аиман аль Завахири есдүгээр сарын 11-нийх шиг халдлага дахин давтагдана гэдгийг анхааруулсан бичлэгийг youtube хуудаснаа нийтэлсэн байлаа.

талын цамхагийг нь мөргөсөн бол үүнээс ердөө 18 минутын дараа мөн нэг онгоц урд талын цамхагийг мөргөж тэнгэр баганадсан хоёр барилга хормын төдийд гал, тоос, хорт утаанд автжээ. Ихэр цамхаг хоёр цаг орчим хугацаанд сүндэрлээсээр байсан ч, эцэстээ хоорондоо 13 минутын зайтай нуран унасан байдаг. Энэ хооронд галд шатаж,

Америкчуудыг айдас хүйдэст автуулж, дэлхий нийтийг цочирдуулсан халдлагыг Аль Кайда бүлэглэл үйлдсэн. Тус бүлэглэлийн удирдагч Осам Бин Ладены АНУ-ын эсрэг ариун дайныг эхлүүлэх эхний цэг нь энэ өдөр тавигдсан юм. Халдлагыг 19 террорист үйлдсэний 15 нь Саудын Араб, үлдсэн нь Арабын нэгдсэн Эмират,

### Хойд Солонгост үер бууж, 60 хүн амиа алджээ

Хойд Солонгосын төрийн мэдлийн KCNA агентлаг тус улсын зүүн хойд этгээдэд олон жилийн дунджаас их хэмжээний хур тунадас орсны улмаас олон тооны барилга байгууламж нурж сүйдсэн талаар өчигдөр мэдээллээ. Улмаар цэргийнхэн болон хотын иргэд аврах ажиллагааг зохион байгуулж байгаа аж. Одоогоор хохирлын хэмжээ хараахан тодорхойгүй байгаа ч, Хятад болон Оростой хиллэх хилийн орчимд байрладаг

Түмэн голын эргээс 60 хүний цогцос олдсон байна. Түүнчлэн 44000 хүн орох оронгүй болжээ. Орон сууц, нийтийн байр нурснаас гадна төмөр зам, автозам, үйлдвэр, хөдөө аж ахуйн бүсүүд ихээхэн хохирол амссан гэдгийг тус улсын Хөдөлмөрийн намын төв хорооны хурлын үеэр албаныхан мэдээлжээ. Хойд Солонгост өмнө нь 2012 оны зун их хэмжээний хур тунадас орсны улмаас 169 хүн амиа алдаж байв.

### "Galaxy note 7"-ыг ашиглахгүй байхыг анхаарууллаа

Өмнөд Солонгос улсын Самсунг Электроникс компани хамгийн сүүлийн үеийн загвар болох "Galaxy Note 7" утсыг ашиглахгүй байхыг солонгосчууддаа анхааруулжээ. Ухаалаг гар утасны салбар дахь хүчтэй өрсөлдөгчдийн нэг тус компанийн шинэхэн бүтээгдэхүүний батарей дэлбэрэх аюултай болохыг АНУ-ын хэрэглэгчдийн аюулгүй байдлын хороо, агаарын тээврийн компаниуд анхааруулсан юм. Тодруулбал, өнгөрсөн долоо хоногт худалдаж авсан "Galaxy Note 7" утасны цэнэглэгчийн оролтоос гэнэт гал асан шатаж буй бичлэгийг хэд хэдэн хэрэглэгч сошиал медиад цацсан юм. Тэгвэл үүнтэй холбогдуулан Самсунг

компани худалдаанд гаргасан утаснуудаа буцаан татсанаас гадна Европт худалдаанд гаргах хугацааг хойшлуулжээ. Самсунг энэ сард Европт нийлүүлэх төлөвлөгөөтэй байсан билээ. Ямартай ч, тус компани өөрийн цахим хуудастаа анхааруулга нийтэлж, нийт солонгосчуудад "Galaxy Note 7" утсыг ашиглахгүй байхыг анхааруулсан байна.



### АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА



Зах зээлдээ тэргүүлэгч худалдааны компанид дараах ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж байна.

#### -МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР



Ажлын байрны зорилго:



Компанийн реклам сурталчилгаа, олон нийтийн харилцааны бодлогын хүрээнд харилцагчид, зах зээл, хэрэглэгчидэд чиглэсэн бүх төрлийн реклам сурталчилгаа, идэвхижүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хянах, үр нөлөөг нь үнэлэх, дүгнэх, борлуулалтыг нэмэгдүүлэх



Тавигдах шаардлага:

- ✓ Маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- ✓ Баримт бичиг боловсруулах, тооцоо судалгаа хийж, дүгнэлт өгөх чадвартай
- ✓ Илтгэх, танилцуулах, олон нийттэй харилцах өндөр үр чадвартай
- ✓ Удирдан зохион байгуулах, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй
- ✓ Хувийн зохион байгуулалт сайтай
- ✓ Багаар ажиллах чадвар сайтай



Бүрдүүлэх материал:

- ✓ CV буюу өөрийн танилцуулга
- ✓ Бакалавр болон магистрын дипломын хуулбар
- ✓ Цахим үнэмлэхний хуулбар
- ✓ Сүүлийн 3 сард авахуулсан өнгөт 3x4 цээж зураг 1%

Холбоо барих:

Материал хүлээн авах хаяг:

Материал хүлээн авах эцсийн хугацаа:



9595-0095



Erinbileg1@gmail.com



2016.09.11

# ШУУРХАЙ МЭДЭЭ

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ХООЛНЫ ХОРДЛОГООС БОЛГООМЖИЛ

Жил бүрийн намар зөвшөөрөлгүй самар, жимсний худалдаа, аялал зугаалга, хурим найр болох нь нэмэгддэг. Үүнтэй холбогдуулан хоолны хордлого, гэдэсний халдварт өвчин ихэсдэг. Хоолны хордлогоор өвчилсөн хүнд ходоод гэдэсний хямралын шинж болох суулгах, хэвлийгээр өвдөх, бөөлжих, хоолонд дургүй болох, халуурах, толгой өвдөх гэх мэт шинж тэмдэг илэрдэг байна. Хэрэв хоол хүнстэй холбоотой дээрх шинж тэмдэг илэвэл эмчид яаралтай хандахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас анхаарууллаа.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Сэтгүүлзүйн шилдэг бүтээлд олгодог "Балдорж" агсны нэрэмжит шагнал гардуулах ёслол найт дахь жилдээ өнгөрсөн баасан гарагт болж өндөрлөв. Энэ удаагийн "Балдорж" шагналын эзэнээр "Засгийн газрын мэдээ" сонинны орлогч эрхлэгч Ц.Цэвэнхэрэн тодорсон юм. Харин дэд байрны эзэнээр "MN 25 дугаар суваг" телевизийн сэтгүүлч Д.Аюурбуны, Б.Ундарлаа нар "1000 төгрөг" зорилот нэвтрүүлгээрээ шалгарлаа. Мөн Монголын залуучуудын холбооноос шалгаруулсан "Тэргүүний залуу сэтгүүлч"-ээр "Өнөөдөр" сонинны Нийгэм, шуурхай мэдээллийн албаны тоймч Л.Ганчимэг шалгарсан.



## "Хог хаягдлаа багасгая, ангилан ялгая, дахин боловсруулья" уралдаан зарлажээ

НҮБ-ын Аж үйлдвэрийн газраас "Хог хаягдлаа багасгая, ангилан ялгая, дахин боловсруулья" сэдэвт зургийн уралдаан зарлажээ. Тус уралдаанд 10-14 насны хүүхдүүд зурагт хуудасны төрөлд, 15-20 насны залуус гэрэл зургийн төрөлд оролцох боломжтой аж. Уралдаанд нэгдүгээр байр эзэлсэн хүүхдэд өргөмжлөл, 500000, хоёрдугаар байр өргөмжлөл, 300000, гуравдугаар байр өргөмжлөл, 200000, дөрөвдүгээр байр өргөмжлөл, 70 мянган төгрөгөөр шагнаж урамшуулах юм. Түүнчлэн тэргүүн байр эзэлсэн хүүхэд бүсийн шалгаруулалтад оролцож, бүсээс шалгарсан нэг хүүхэд Австрийн Вена хотод болох "Шилдэг зурагт хуудас" өргөмжлөлийн гардан авах ёслолд оролцох эрхээр шагнуулах аж. Мөн хүүхэд, залуусын ирүүлсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан олон нийтэд танилцуулах бөгөөд бүтээлийг энэ сарын 25-ныг дуустал хүлээн авна.

## "Хэлмэгдэгсдийн хөшөө"-нд цэцэг өргөв

1996 оноос эхлэн жил бүрийн есдүгээр сарын 10-нд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэж ирсэн билээ. Энэ өдрийг тохиолдуулан өнгөрсөн бямба гарагт Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, УИХ-ын дарга М.Энхболд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат нар болон УИХ, Засгийн газрын гишүүдийн төлөөлөл, яам, агентлаг, зэвсэгт хүчин, хэлмэгдэгсдийн үр хүүхэд, ах дүү, төрөл төрөгсөд Хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлжээ.

## Энэ сарын 26-нд цаг ухарна

Манай улс 1960 онд анх цаг урагшуулах зохицуулалт хийж байсан түүхтэй. Гэвч үүнийг 1999 онд хүчингүй болгож, 2001 онд дахин сэргээжээ. Цаг урагшуулах зохицуулалтыг 2005 онд хүчингүй болгосон бөгөөд өнгөрсөн оны гуравдугаар сард сэргээн цаг урагшуулах, ухрах горимд шилжсэн юм. Өдөр уртасч байгаатай холбогдуулан нарны эртний ашиглаж ажлаа амжуулах, цахилгааны хэмнэлт гаргах зорилгоор өнгөргөч гуравдугаар сарын 25-26-нд шилжих шөнө 02:00 цагт цагийг нэг цагаар урагшуулаад байсан юм. Тэгвэл энэ сарын 25-26-нд шилжих шөнө өвлийн цагийн хуваарьт шилжин цагийг нэг цагаар ухраах аж.

## Хорио цээрийн дэглэмийг чангатгав

Баян-Өлгий аймагт ямааны тахал өвчин гарчээ. Одоогийн байдлаар тус аймгийн Булган суманд өвчилсөн бог малын тоо 15369 гаруй толгойд хүрсэн байна. Тиймээс Улаанхус, Цүнхэл багийн нутагт тогтоогдсон хорио цээрийн дэглэмд хүч нэмэгдүүлж хорио цээрийн дэглэмийг чангатгах шийдвэрийг орон нутгийн захиргаанаас гаргажээ. Хорио цээрийн дэглэмийг чангатгасантай холбоотойгоор олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, уулзалт зохион байгуулахыг түр хугацаагаар хориглосон тухай эх сурвалж мэдээллээ.

## Хиймэл нууранд осолдсон хүнийг хайж байна

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Санжинт багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг Бурхантын хөндийн алтны уурхайн хиймэл нууранд иргэн 24 настай Б осолдсон хэрэг өнгөрсөн баасан гарагийн 20:30 цагт гарчээ. Дуудлагын дагуу тус аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах, аврах 55 дугаар ангийн зургаан албан хаагч, Цагдаагийн гурван албан хаагч, тус уурхайн 15 ажилтан нийт 24 хүн, гурван техник хэрэгсэлтэйгээр ажиллаж байна. Одоогоор осолдсон хүнийг погос олдоогүй байна. Мөн урьд шөнө Архангай аймгийн Булган сумын Тамир багийн "Хөх эрэг" гэдэг газар "Тамирын гол"-ын гармайд /Аймгийн төвөөс баруун зүгт 30 км-т/ УАЗ-469 загварын автомашин, зургаан зорчигч голд суусан байна. Тэднийг аймгийн Онцгой байдлын газрын таван албан хаагч, 1 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж татан гаргажээ.

# МАНАЙ УЛСАД БАЙГАА ИХЭНХ АВРАХ ХАНТААЗ СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАДАГГҮЙ

Н.БАТЗАЯА

*Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны Дотоодын усан замын тээвэр хариуцсан мэргэжилтэн Г.Золбоогоос усан замын тээвэр түүний аюулгүй ажиллагаа, аврах хантаазны талаар зарим зүйлийг тодрууллаа.*

-Сүүлийн үед дотоодын болон гадаадын жуулчдын тоо эрс нэмэгдэх болсон. Үүнийг дагаад Хөвсгөл далайд аялах жуулчдын тоо ч нэмэгдсэн байх? -Улаанбаатар хотоос Хөвсгөл аймаг болон Хатгалтосгонтой 900 км хатуу хучилттай авто замаар шууд холбогдсон байгаа. Үүнтэй холбоотойгоор дотоод, гадаадын жуулчид маань автомашинаар 12-15 цаг давхиад Хөвсгөл нуурын эрэгт хүрч амарч байна. Би яг нарийн тоог нь мэдэхгүй байна. Гэхдээ албан бус тоогоор өнгөрсөн жил дотоодын 56 мянга гаруй жуулчин, гадаадын 4500 гаруй жуулчид Хөвсгөл нууранд амарсан бол энэ жил дотоодын 37 мянга гаруй, гадаадын 2700 гаруй жуулчин ирсэн байна.

-Өнгөрсөн сард усан замын тээвэрт их ноцгой осол гарч, таван хүн амиа алдлаа. Ер нь Хөвсгөл нууранд гарч байгаа анхны осол биш шүү дээ. Өмнө нь хэчнээн хүн амиа алдаж байсан бэ? -Хөвсгөл нууранд гарч буй усан замын тээврийн хэрэгсэлтэй холбоотой хүний амь эндсэн анхны осол биш, түүнчлэн санамсаргүй байдлаар болон санаатай усанд унаж амиа алдсан тохиолдол ч мөн бий. Усан замын тээврийн хэрэгслээр аялж яваад осолдсон ихэнх тохиолдлыг үзэхэд зорчигчдын хайхрамжгүй байдал болон усан замын тээврийн хэрэгсэл жолоодогч буй жолоодогчийн хариуцлагатай шууд холбоотой байдаг.

Завь жолоодогч маань зорчигчдод шаардлага тавихгүй, аврах хантааз өмсүүлээгүйгээс, түүнчлэн зорчигчид аврах хантаазыг зөв өмсөж хэрэглээгүйгээс, завь жолоодогчийн шаардлагыг биелүүлэхгүй завь катер хөдөлгөөнд орсон үед босч зогсон зураг авахуулах, бичлэг хийх зэргээс болж осол гарах тохиолдол бий. Хэдэн хүн нас барсан бэ гэдэг яг нарийн тоог сайн мэдэхгүй байна. Цагдаагийн байгууллага эсвэл ОБЕГ-аас нарийн тоог авч болох байх.

-Усан замын тээвэр яалт ч үгүй бидний анхаарал хандуулах ёстой салбар болжээ. Энэ тээврийг сонирхож, үйлчлүүлэх хүмүүсийн тоо ч нэмэгдэж. Мөн усан замын тээвэрээр бизнес эрхэлж байгаа хүмүүс ч байна. Тэгэхээр аврагч хантааз ямар үүрэгтэй юм бэ. Энэ талаар мэдээлэл өгөхгүй юу? -Аврах хантаазны төрөл, ангилал, зориулалт бүр өөр. Нийт дөрвөн төрлийн аврах хэрэгсэл бий. Зөвхөн зорчигчдод зориулсан аврах хантааз, усан спортоор хичээллэдэг хүнд зориулсан, загас барих загасчлах дургай хүмүүст зориулсан хантааз байдаг. Зорчигчдод зориулсан аврах хантааз бол маш олон давуу талтай. Тухайлбал, тухайн зорчигч сэлж чаддаг ч бай, үгүй ч бай ямар нэгэн байдлаар завь катераасаа унаж, толгойгоо цохин ухаан алдахад тухайн зорчигчийг усанд унахад 2-3 секундын дотор толгойг нь дээш гаргаж ирэх үүрэгтэй. Ямар ч тохиолдолд ус залгуулдаггүй. Хөлөг онгоцны багийн гишүүд болон усан спортоор хичээллэгч тамирчдын өмсдөг хантааз нь тухайн хүний хөдөлгөөнд саад учруулдаггүй. Харин сэлэхэд дэмжлэг үзүүлдэг. Зорчигчийн аврах хантааз мэдээж тухайн хүнийг аврах үүрэгтэй гэж

ойлгож болно.

-Одоогийн хэрэглэж байгаа аврах хантааз стандарт хангаж чадаж байна уу? -Манай улсад олон төрөл, загварын хантааз борлуулагдаж байна. Зарим хувиараа зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрсдөө захиалж авч байгаа. Гэхдээ зарим хантааз нь ямар үйлдвэрийнх нь мэдэгдэхгүй, лого тэмдэг тэмдэглэгээ байхгүй эсвэл өөрсдөө оёулсан гэмээр байдаг л даа. Мөн загасчдад зориулсан олон төрлийн халаастай хантааз бий. Манайд хэрэглэгдэж байгаа ихэнх хантааз шаардлага хангахгүй байна. Шаардлага

завин дээр гарахдаа ихэвчлэн ямар зөрчил гаргадаг вэ? -Завь жолоодогч буй жолоодогчийн тавьсан шаардлагыг биелүүлдэггүй. Мэдээж жолоодогч аль болох тав тухтай аялуулахыг хичээж байгаа. Мөн таны амь насыг хариуцаж яваа хүн болохоор аливаа ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч зорчигчдод шаардлага тавих үүрэгтэй. Иргэд ихэвчлэн шаардлага биелүүлэхгүй босч зогсох, үсэрч дэвхцэх, нэг тал руугаа шахааж завины тэнцвэрт байдлыг алдагдуулах, нэг тал руугаа тонгойж гараараа ус хутгах, архидаан согтуурах гэх мэтчилэн зөрчлүүд гаргаж байгаа нь их ажиглагддаг.

-Завьчдад зориулсан сургалт зохион байгуулагддаг уу? -Бусад хөгжингүй орнуудад өдөрт 2-4 цагаар 5-7 хоногийн хугацаатай онол дадлагын хичээл ордог. Онлайнаар шалгалт тест өгөөд чүнэмлэхээ авч усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй болдог юм билээ. Манайд жил бүрийн 6-7 дугаар сард хоёр хоног Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулагддаг. Багш сурган хүмүүжүүлэгч болон материаллаг бааз, дадлага хийх газар нутаг, техникээс хамаараад тэр бүр байнгын зохион байгуулж чаддаггүй. Жилд нэг удаа л сургалт явагддаг.

-Хариуцлагагүй байдлаас болж хүний амь эрсэдмээргүй байна. Үүнийг зохицуулахын тулд нэгдсэн журмаар ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ? -Хууль, дүрэм, журмын тавигдах шаардлагыг өндөр болгох хууль, дүрэм журмын хэрэгжилтэд анхаарч завь катерын үзлэг шалгалтыг олон болгох хэрэгтэй. Завьт эргүүлийг ихэсгэх, хяналт, шаардлага тавьж буй байгуулагуудын хүн хүч, техникийн асуудлыг нэмэгдүүлэх шаардлагатай. Бусад гол, мөрөнд нууранд хяналтын баг бүрдэхүүн хүн хүч нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг бий болгох Хөвсгөл нууранд ЭКО усан замын тээврийн хэрэгслийг шинээр нэвтрүүлэх, Монгол Улсад шинээр орж ирж буй бага оврын завь катерг техникийн хяналт тавих үндэсний стандарт боловсруулах хэрэгтэй.

...Манай улсад олон төрөл, загварын хантааз борлуулагдаж байна. Зарим хувиараа зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрсдөө захиалж авч байгаа. Гэхдээ зарим хантааз нь ямар үйлдвэрийнх нь мэдэгдэхгүй, лого тэмдэг тэмдэглэгээ байхгүй эсвэл өөрсдөө оёулсан гэмээр байдаг л даа...

хангаж байгаа хантааз бий. Шаардлага хангаж буй аврах хантааз нь ISO болон SOLAS конвенци мөн Level-100, Level-50 гэсэн тэмдэглэгээтэй. Мөн тухайн аврах хантаазны даацын тэмдэглэгээ болон өмсөх зааврыг тэмдэглэсэн байдаг.

-Аврах хантаазны стандарт ямар байдаг юм бэ? -Олон улсын стандарт ISO 12402 аврах хантаазны багц стандарт байна. Энэхүү багц стандартын дөрвөн дэх хэсэг болох зорчигчдод зориулсан аврах хантааз буюу 12402-4 -ийг 2014 онд Үндэсний стандарт болгон батлуулсан.

-Завьчид болон жуулчид

**Хүчингүйд тооцов**

0004528 гэрчилгээний дугаартай, Y2201000214 улсын бүртгэлийн дугаартай УБ хот, СХД, 1-р хороолол, 15-р хороо, 13-р байр 349 тоотод байрлах компанийн гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Y-2205016024 Улсын бүртгэлийн дугаартай байрны гэрчилгээг гэсэн тул хүчингүйд тооцов.

# STRESS

ЗОГС, НЭГ АГШИН

## Хариуцлага мэдрүүлсэн

## “СОЛИОТЭЭЭ” ТООЛОЛТ

Н.БАТЗАЯА

Еодон төрх, стиль имиж, өвөрмөц дуу хоолойгоороо бусдаас ялгардаг реппер Rokit Bay өнгөрсөн баасан гарагт шүтэн бишрэгчиддээ зориулан “Хариуцлага” тоглолтоо Үндэсний соёл амралтын хүрээлэнд нийжэр хийлээ. Тэрбээр өнгөрсөн тавдугаар сард “Хариуцлага” нэртэй цомгоо худалдаанд гаргасан бөгөөд цомгийн тоглолтоо энэ зуны сүүлийн шоу болгон залуустаа зориулсан нь энэ юм. “Хариуцлага” тоглолтын ерөнхий ивээн тэтгэгчээр Мобиком корпораци, хамтран зохион байгуулагчаар урлаг, спортын салбарын идэвхтэй ивээн тэтгэгч байгууллагын нэг болох “Хаан банк” ажиллажээ. Түүний тоглолтын салхийг хагалан реппер NMN ая дуугаа өргөсөн бол урилгаар реппер Gee оролцов. Реппер Rokit Bay Gee-тэй хамтран тайзнаа “Микрофоны ард” дуугаа дуулсан нь тоглолтын нэгэн гэнэтийн бэлэг байлаа. Тоглолтын гэнэтийн бэлэг үүгээр ч дууссангүй. Тус тоглолтын хамтран зохион байгуулагч “Хаан банк”-ны хамт олон үзэгчдийн дундаас азтан тодруулж, 300 мянган төгрөгөөр шагнасан юм. Үргэлж л сонин содон зүйлийг сэтгэж, бусдаас онцгойрдог тэрбээр энэ удаагийн тоглолтоо амьд хөгжимтэй хослуулан хийсэн нь энэ үдшийн содон тоглолт болж чадсан гэхэд болно.

Тодруулбал, энэ үдэш тэрбээр фэнүүддээ зориулан “Бороо” дуугаа амьд хөгжимтэйгөөр хүргэсэн. Тэрбээр “Бороо” дуугаа ээж, эмээгээ төсөөлж, санаа аван бүтээсэн гэдэг. Амьдралын зовлон гуниг, хагацал шаналыг сөрөн гарч чадсан хүчирхэг, зоригтой эмэгтэйчүүдийн тухай өгүүлэх уг дуу амьд хөгжимтэй хосолсон нь залуусын чинийг баясаж байсан гэхэд хилсдэхгүй. Тоглолт “Хэний хүүхэд вэ”, “Тасархай залуу”, “Диваажингийн нулимс”, “Ганцаардсан улстөрч”, “Эвшээсэн дагина”, “Аюултай бүс”, “Бор арьст Гаамп”, “3.2.1” зэрэг дуугаар үргэлжилсэн юм. “Хариуцлага” тоглолтод түүний тавдугаар сард гаргасан “Хариуцлага” цомогт орсон дуунууд дуулагдаж байлаа. Реппер Rokit Bay тоглолт болохоос өмнө нэгэн сонинд өгсөн ярилцлагадаа “Хип хоп болон амьд хөгжмийн урсгал тэс өөр улс оронд үүсч, хөгжсөн ч гэлээ хамтдаа сайхан сонсогддог. Би хувьдаа тэгж боддог. Харин хүн бүхэн өөр өөрийнхөөрөө хүлээн авна. Хип хоп, амьд хөгжимтэй хэр зохинож байгааг миний “Хариуцлага” тоглолтоос ирж үзээд дүгнэлтээ хийгээрэй л гэж хэлэе” хэмээн өгүүлсэн байдаг. Тэгвэл өнгөрсөн баасан гарагт тэрбээр “UFO” хамтлагтай хамтран жинхэнэ амьд хөгжим, хип хоп урсгалын зохицлыг үзүүлж чадлаа.

Түүний тоглолтод ихэвчлэн өсвөр насны хүүхэд, залуус ирсэн нь түүнд өөрт нь ч гэсэн хариуцлага бий гэдгийг харуулж байсан юм. Учир нь түүний хийх үйлдэл, хэлэх үг, уран бүтээлээрээ илэрхийлж буй санааг өсвөр насны хүүхэд, залуус харж, үлгэр дуурайлал авдаг нь ч илэрхий. Тиймээс реппер залууд ч гэсэн шүтэн бишрэгчдийнхээ өмнө үррэх хариуцлага бий. Ямартай ч Реппер Rokit Bay-ийн “Хариуцлага” тоглолт нэгэн үдэш залуусыг хөгжөөж, амьд хөгжим, хип хоп урсгалтын дор нэгтгэж чадлаа. Тоглолтыг товчхон дүгнээд хэлэхэд хариуцлагыг мэдрүүлсэн “солиотэээ” тоглолт паркыг доргиолоо.



Гэрэл зургийг Г.АРУУХИНИН

## “ШИНЭ ТӨГӨЛ”-г тавтай морил



Олон Улсын стандартад нийцсэн "Шинэ төгөл" цэцэрлэг нь шинээр ашиглалтад орж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. "Шинэ төгөл" цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшинд бэлтгэнэ. Мөн хүүхдийг тань эрүүл, аюулгүй, цэвэрхэн, тохилог орчинд сурч хүмүүжих нөхцөлөөр бүрэн хангасан. Анги бүрийг камержуулсан тул та хүүхдээ ажил болон гэрээсээ хянаж боломжтой.


Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ. Багш боловсон хүчний хувьд олон жил боловсролын байгууллагад ажилласан мэргэжлийн эрхлэгч, чадварлаг багш баг хамт олноос бүрдсэн. Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Та хүүхдийнхээ хоол хүнсэнд санаа зовох хэрэгтэй. Манай цэцэрлэг өдрийн 5 удаагийн хоолтой. Хүнсний материалыг долоо хоног бүр шинэчилж татдаг бөгөөд хүнсний материалаа татах үедээ мэргэжлийн эмч, нярав байлцаж хүлээн авдаг. Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминээр баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.



**ТА ХҮҮХДЭЭ МАНАЙ ЦЭЦЭРЛЭГТ БҮРТГҮҮЛЭЭРЭЙ**  
Холбоо барих утас: 99094864, 99198435

### Бидэнд тохиолдсон



Стейн Дакын өгүүлэл

Ахын найз ирээд “Гал байна уу” гэхээр нь “Байгаль” шүдэнз аваад өгчихлөө. Тэгсэн 10 зурлаа байдаггүй ээ. Уугиад л ерөөсөө асахгүй байсан чинь “Өө энэ муу чинь шал хэрэггүй хог байна” гээд шидчихсэн чинь ахын эхнэр “Наадах чинь хэрэгтэй. Авдар дээр тавьчих.

Энүүгээр тамхиа асаа” гээд орос шүдэнз өглөө. Тэгсэн нөгөөх нь ганц зураад асч байна. Ахын найз тамхиа асаачихаад “Энэ уугиад асдаггүй шүдэнз юунд хэрэг болох вэ” гэсэн чинь эгч “Манай нөхөр орой унгахад нь уугиулдаг юм. Ойрхон тавьчих” гэдэг юм даа. Хаха

### ОДДЫН АМЬДРАЛ

## Жастин Биберийн найз бүсгүй ШИВЭЭС хийлгэжээ

Б.ДАВАА

Канадын дуучин, залуу од Жастин Биберийн шинэ найз бүсгүй гэдгээрээ олны анхааралд өртөх болсон загвар өмсөгч София Ричи шивээс хийлгэжээ. Бүсгүй Нью-Йоркийн нэлээд нэртэй шивээсчнээр хоёр төрлийн шивээс хийлгэсэн байх бөгөөд бүсгүйн дунд хуруундаа хийлгэсэн загалмайн шивээс нь олны анхаарлыг татаж эхлээд байна. Дуучин Лайонел Ричигийн охин София Ричи өнгөрсөн сараас эхлэн дуучин Жастин Бибертэй болж эхэлсэн байдаг. Тэгвэл модель бүсгүй найз залуутайгаа яг адилхан загалмайг өөрийн дунд хуруундаа шивүүлжээ. Жастин Бибер нүдний орчимдоо жижиг загалмайн шивээстэй бөгөөд Софиягийн хийлгэсэн шивээсний загвар нь Жастиньхтай туйлын ижилхэн гэнэ. Түүнчлэн, хосууд шивээсээ нэг шивээсчнээр хийлгэсэн төдийгүй загварыг нь ч яг адилхан байхаар захиалсан сурагтай.



## Тайлор Свифт шүтэн бишрэгчдээ 5000 АМ.ДОЛЛАР ХАНДИВЛАЖЭЭ

Хөгжмийн ертөнцийн одод дундаа хамгийн өгөөмөр гэдгээрээ алдартай дуучин Тайлор Свифт зам тээврийн осолд өртөж амиа алдсан шүтэн бишрэгчийнхээ буяны ажилд зориулан 5000 ам.доллар хандивлажээ. Дуучин бүсгүйн үнэнч фэнүүдийн нэг 18 настай

Кэйт гэх охин ослын улмаас амь үрэгдсэн байна. Улмаар эцэг эх нь охиныхоо оршуулгын зардлыг олохын тулд хандивын данс нээж, сайхан сэтгэлт хүмүүсээс тусламж хүсчээ. Тэгвэл тэрхүү дансаар дамжуулан Тайлор Свифт их хэмжээний мөнгөн хандив өргөсөн байна. Энэ тухай талийгаач охины эгч нь инстаграмм хуудсаараа дамжуулан мэдэгдсэн аж. Гэтэл Тайлор Свифтын хандив өргөсний дараа маш олон хүмүүс хандивын дансанд хандаж, эдүгээ охины буяны ажилд зарцуулагдах мөнгө 36 мянган ам.доллар болсон гэнэ.